



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БНА-2026/020/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Баянхонгор хот
2026.02.25

2026

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер: М.Алтантуяа
Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
Аудитор: Н.Батчимэг
Утас: 91113253 Цахим хаяг: batchimegn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2026.02.25 № 2/126

танай _____-ны № _____-т

Г **Хязгаарлалттай дүгнэлт** Г

ШИНЭЖИНСТ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Э.АМГАЛАНБАЯР ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчтай цалингийн тооцоо хийгээгүй
- Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээс илүү дэмжлэг олгосон
- Зориулалт бусаар хөрөнгө зарцуулсан зэрэг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухайн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах

6426050219
/2026 он/1. бичиг хэрэг/тоот/2. а4
албан тоот.docx

үндэслэл болно", 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтыг тус тус зөрчсөн, УСНББОУС-1 санхүүгийн тайлангийн толилуулга, УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Иж бүрэн байх", "Үнэлгээ ба хуваарилалт", "Ангилал" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

"Сэкер русорсус монголиа" ХХК нь нийгмийн хариуцлагын гэрээний хүрээнд 550,000.0 мянган төгрөгөөр сумын Засаг даргын Тамгын газрын байрыг засварласан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 166,299.4 мянга, хандиваар аж ахуй нэгжээс 172,178.4 мянга, бусад байгууллагаас 2,952,677.1 мянга нийт 3,291,154.9 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс 36,264.4 мянган төгрөг буюу 36.8 хувийг биеийн тамирын уралдаан тэмцээн, шагнал урамшуулал, бэлэг дурсгалд зарцуулсан байна.

Сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс 36,264.4 мянган төгрөг буюу 36.8 хувийг биеийн тамирын уралдаан тэмцээн, шагнал урамшуулал, бэлэг дурсгалд зарцуулсан байна.

Бусад асуудал

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 11 зорилтын хүрээнд 79 арга хэмжээг

хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 91.2 хувиар тайлагнасан байна.

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	301,325,200.28	352,801,988.28
33	АВЛАГА	2,492,700.00	2,418,360.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	100,000.00	25,660.00
336	Зээлийн авлага	2,392,700.00	2,392,700.00
3361	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	2,392,700.00	2,392,700.00
33612	Хувь хүмүүст олгосон зээл	2,392,700.00	2,392,700.00
35	БАРАА МАТЕРИАЛ	106,631,600.28	179,682,728.28
351	Түүхий эд материал	38,183,138.28	38,183,138.28
35110	Тусгай зориулалттай материал	38,183,138.28	38,183,138.28
35300	Бэлэн бүтээгдэхүүн	44,200,000.00	77,800,000.00
354	Хангамжийн материал	14,055,930.00	40,307,058.00
35410	Бичиг хэргийн материал	3,634,280.00	3,634,280.00
35420	Аж ахуйн материал	10,421,650.00	36,672,778.00
35600	Мал амьтад	10,192,532.00	23,392,532.00
36	НӨӨЦИЙН БАРАА	192,200,900.00	170,700,900.00
36600	Бусад нөөц	192,200,900.00	170,700,900.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,182,952,739.57	6,075,992,670.04
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,182,952,739.57	6,075,992,670.04
392	Биет хөрөнгө	3,034,125,239.57	5,927,202,670.04
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,579,863,655.28	6,122,126,823.28
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,129,523,297.44	-1,338,547,405.02
39203	Авто-тээврийн хэрэгсэл	433,360,162.67	931,427,477.67
39204	Хуримтлагдсан элэгдэл	-170,284,014.28	-188,431,518.04
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	329,105,545.43	285,268,977.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	-186,801,489.21	-168,562,948.87
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	72,004,549.00	96,503,570.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-63,052,402.00	-27,606,543.17
39214	Бусад үндсэн хөрөнгө	381,576,376.10	447,341,438.10
39215	Хуримтлагдсан элэгдэл	-212,257,245.98	-232,317,201.84
39217	Ном	133,400.00	00.00
393	Биет бус хөрөнгө	148,827,500.00	148,790,000.00
39301	Програм хангамж	1,150,000.00	1,150,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,112,500.00	-1,150,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	148,790,000.00	148,790,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,484,277,939.85	6,428,794,658.32
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,206,726.40	61,736,634.50
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,206,726.40	61,736,634.50
413	Өглөг	1,206,726.40	61,736,634.50
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,206,726.40	2,678,673.50
4136	Бусад өглөг	00.00	59,057,961.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	59,057,961.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,483,071,213.45	6,367,058,023.82

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан			
51	Засгийн газрын хувь оролцоо	3,483,071,213.45	6,367,058,023.82
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	684,879,255.00	684,879,255.00
51101	Өмч: - төрийн	684,879,255.00	684,879,255.00
512	Хуримтлагдсан үр дүн	2,249,075,758.36	5,133,062,568.73
51210	Өмнөх үеийн үр дүн	2,249,075,758.36	2,249,075,758.36
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	2,883,986,810.37
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	549,116,200.09	549,116,200.09
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,484,277,939.85</u>	<u>6,428,794,658.32</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,180,904,576.07	4,906,059,705.35
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	816,795,124.57	3,207,562,831.35
120	Нийтлэг татварын бус орлого	816,795,124.57	3,207,562,831.35
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	21,570.00	2,591,180.35
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,570.00	2,310,000.00
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	281,180.35
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,364,109,451.50	1,698,496,874.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	98,173,751.50	2,537,374.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,339,451.50	2,537,374.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	49,834,300.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,265,935,700.00	1,695,959,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,265,935,700.00	1,695,959,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,478,585,723.72	1,956,146,828.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,478,585,723.72	1,956,146,828.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,400,036,825.87	1,785,962,666.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	706,286,645.09	876,205,312.96
210101	Үндсэн цалин	403,439,436.59	387,395,944.10
210102	Нэмэгдэл	298,486,308.50	452,234,269.36
210104	Урамшуулал	4,360,900.00	36,575,099.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,533,791.36	114,635,300.00
210201	Тэтгэврийн даатгал	57,711,335.21	77,985,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,082,666.46	9,146,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,114,800.17	4,579,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,324,997.92	4,578,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,299,991.60	18,346,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	96,989,088.00	128,690,718.00
210301	Гэрэл, цахилгаан	25,477,648.00	34,599,856.00

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан			
210302	Түлш, халаалт	71,511,440.00	94,090,862.00
2104	Хангамж, бараа материалын зардал	47,497,440.00	60,741,270.00
210401	Бичиг хэрэг	8,260,000.00	8,914,150.00
210402	Тээвэр, шатахуун	30,167,140.00	43,720,650.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,529,000.00	3,371,950.00
210404	Ном, хэвлэл	126,000.00	42,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,400,000.00	3,901,520.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,015,300.00	791,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,000,000.00	6,000,000.00
210604	Урсгал засвар	20,000,000.00	6,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	6,116,200.00	5,194,200.00
210702	Дотоод албан томилолт	6,116,200.00	5,194,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,616,780.60	66,624,537.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	34,051,547.60	65,338,942.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	800,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	588,675.00	485,595.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	351,768.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	32,000.00	00.00
210807	Газрын төлбөр	792,790.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	400,996,880.82	527,871,328.12
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	119,966,705.00	129,487,402.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	495,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	281,030,175.82	397,888,926.12
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	78,548,897.85	170,184,162.49
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,304,447.50	48,292,791.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	500,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	26,672,791.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	28,112,447.50	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,192,000.00	21,120,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	23,364,128.95	119,176,359.49
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,364,128.95	119,176,359.49
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	23,880,321.40	2,715,012.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,880,321.40	2,715,012.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	702,318,852.35	2,949,912,876.78
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	264,049,544.00	65,926,066.41
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	4,280,000.00	226,066.41
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	259,769,544.00	65,700,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-264,049,544.00	-65,926,066.41
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	438,269,308.35	2,883,986,810.37

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,364,131,021.50</u>	<u>1,701,088,054.35</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,570.00	281,180.35
120	Нийтлэг татварын бус орлого	21,570.00	281,180.35
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	21,570.00	281,180.35
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,570.00	00.00
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	281,180.35
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,364,109,451.50	1,700,806,874.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	98,173,751.50	4,847,374.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,339,451.50	2,537,374.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	49,834,300.00	2,310,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,265,935,700.00	1,695,959,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,265,935,700.00	1,695,959,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,293,585,021.50</u>	<u>1,534,788,654.35</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,293,585,021.50	1,534,788,654.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,215,036,123.65	1,364,604,491.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	703,354,956.30	874,659,025.86
210101	Үндсэн цалин	407,693,231.41	385,840,657.00
210102	Нэмэгдэл	291,302,924.29	452,243,269.36
210104	Урамшуулал	4,358,800.60	36,575,099.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,930,053.75	114,635,300.00
210201	Тэтгэврийн даатгал	59,792,499.55	77,985,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,034,330.30	9,146,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,517,165.15	4,579,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,517,159.15	4,578,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,068,899.60	18,346,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	96,989,088.00	119,517,357.00
210301	Гэрэл, цахилгаан	15,261,728.00	21,158,299.00
210302	Түлш, халаалт	81,727,360.00	98,359,058.00
2104	Хангамж, бараа материалын зардал	49,067,440.00	44,347,369.00
210401	Бичиг хэрэг	6,282,400.00	7,875,950.00
210402	Тээвэр, шатахуун	32,675,740.00	27,537,650.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,826,000.00	3,371,950.00
210404	Ном, хэвлэл	168,000.00	84,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,100,000.00	4,686,819.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд	1,015,300.00	791,000.00

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

	зүйлс		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,000,000.00	14,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	8,000,000.00
210604	Урсгал засвар	20,000,000.00	6,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,009,200.00	5,604,200.00
210702	Дотоод албан томилолт	5,009,200.00	5,604,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	102,643,583.00	57,513,988.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	100,067,350.00	56,228,393.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	800,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	588,675.00	485,595.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	362,768.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	32,000.00	00.00
210807	Газрын төлбөр	792,790.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	150,041,802.60	134,327,252.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	150,041,802.60	133,832,252.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	495,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	78,548,897.85	170,184,162.49
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,304,447.50	48,292,791.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	500,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	26,672,791.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	28,112,447.50	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,192,000.00	21,120,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	23,364,128.95	119,176,359.49
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,364,128.95	119,176,359.49
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	23,880,321.40	2,715,012.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,880,321.40	2,715,012.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>70,546,000.00</u>	<u>166,299,400.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	70,546,000.00	166,299,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	70,546,000.00	166,299,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	70,546,000.00	166,299,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	70,546,000.00	166,299,400.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-70,546,000.00</u>	<u>-166,299,400.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	684,879,255.00	847,916,848.19	1,410,503,861.22	00.00	2,943,299,964.41
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	684,879,255.00	847,916,848.19	1,410,503,861.22	00.00	2,943,299,964.41
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	365,861,333.83	00.00	365,861,333.83
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	684,879,255.00	549,116,200.09	2,249,075,758.36	00.00	3,483,071,213.45
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	684,879,255.00	549,116,200.09	2,249,075,758.36	00.00	3,483,071,213.45
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	684,879,255.00	549,116,200.09	2,249,075,758.36	00.00	3,483,071,213.45
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	2,883,986,810.37	00.00	2,883,986,810.37
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	684,879,255.00	549,116,200.09	5,133,062,568.73	00.00	6,367,058,023.82

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Үзүүлэлт	Тайлант оны		Тайлант оны	
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,823,276,500.00	1,577,064,320.86	246,212,179.14	86.5
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,822,276,500.00	1,577,064,320.86	245,212,179.14	86.5
Орон нутгийн төсвөөс	1,822,276,500.00	1,576,783,140.51	245,493,359.49	86.5
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.00	281,180.35	718,819.65	28.1
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	00.00	1,000,000.00	0.0
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	281,180.35	-281,180.35	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,823,276,500.00	1,577,064,320.86	246,212,179.14	86.5
УРСГАЛ ЗАРДАЛ	1,823,276,500.00	1,577,064,320.86	246,212,179.14	86.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,768,501,600.00	1,528,771,529.86	239,730,070.14	86.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	917,614,700.00	874,659,025.86	42,955,674.14	95.3
Үндсэн цалин	411,605,900.00	385,840,657.00	25,765,243.00	93.7
Нэмэгдэл	472,956,000.00	452,243,269.36	20,712,730.64	95.6
Урамшуулал	33,052,800.00	36,575,099.50	-3,522,299.50	110.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	114,701,800.00	114,635,300.00	66,500.00	99.9
Тэтгэврийн даатгал	77,997,200.00	77,985,000.00	12,200.00	100.0
Тэтгэмжийн даатгал	9,176,100.00	9,146,700.00	29,400.00	99.7

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

ҮОМШӨ-ний даатгал	4,588,100.00	4,579,600.00	8,500.00	99.8
Ажилгүйдлийн даатгал	4,588,100.00	4,578,000.00	10,100.00	99.8
Эрүүл мэндийн даатгал	18,352,300.00	18,346,000.00	6,300.00	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	126,590,300.00	119,517,357.00	7,072,943.00	94.4
Гэрэл, цахилгаан	28,000,000.00	21,158,299.00	6,841,701.00	75.6
Түлш, халаалт	98,590,300.00	98,359,058.00	231,242.00	99.8
Хангамж, бараа материалын зардал	68,464,000.00	44,347,369.00	24,116,631.00	64.8
Бичиг хэрэг	10,400,000.00	7,875,950.00	2,524,050.00	75.7
Тээвэр, шатахуун	39,800,000.00	27,537,650.00	12,262,350.00	69.2
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,064,000.00	3,371,950.00	692,050.00	83.0
Ном, хэвлэл	400,000.00	84,000.00	316,000.00	21.0
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	12,180,000.00	4,686,819.00	7,493,181.00	38.5
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,620,000.00	791,000.00	829,000.00	48.8
Эд хогшил, урсгал засварын зардал	32,000,000.00	25,054,400.00	6,945,600.00	78.3
Багаж, техник, хэрэгсэл	20,000,000.00	19,054,400.00	945,600.00	95.3
Урсгал засвар	12,000,000.00	6,000,000.00	6,000,000.00	50.0
Томилолт, зочны зардал	11,100,000.00	5,604,200.00	5,495,800.00	50.5
Дотоод албан томилолт	11,100,000.00	5,604,200.00	5,495,800.00	50.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	88,058,000.00	57,513,988.00	30,544,012.00	65.3
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	84,800,000.00	56,228,393.00	28,571,607.00	66.3
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	800,000.00	0.00	100.0
Даатгалын үйлчилгээ	800,000.00	485,595.00	314,405.00	60.7
Тээврийн хэрэгслийн татвар	498,000.00	00.00	498,000.00	0.0
Тээврийн хэрэгслийн оношлогоо	160,000.00	00.00	160,000.00	0.0
Газрын төлбөр	1,000,000.00	00.00	1,000,000.00	0.0
Бараа үйлчилгээний бусад зардал	421,072,800.00	287,439,890.00	133,632,910.00	68.3
Бараа үйлчилгээний бусад зардал	421,072,800.00	286,944,890.00	134,127,910.00	68.1
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	495,000.00	-495,000.00	
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54,774,900.00	48,292,791.00	6,482,109.00	88.2
Бусад урсгал шилжүүлэг	54,774,900.00	48,292,791.00	6,482,109.00	88.2
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,000,000.00	500,000.00	2,500,000.00	16.7
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,774,900.00	26,672,791.00	102,109.00	99.6
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	25,000,000.00	21,120,000.00	3,880,000.00	84.5

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

АЖИЛЛАГСАДЫН ТОО	24	24	0.00	100.0
Удирдах ажилтан	6	6	0.00	100.0
Гүйцэтгэх ажилтан	13	13	0.00	100.0
Үйлчлэх ажилтан	5	5	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,847,374.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,847,374.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,132,362.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,132,362.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,132,362.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	2,715,012.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,847,374.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,847,374.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,537,374.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,310,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үр дүнг нэгтгэв.

1. Бүтэц орон тоог сумын ЗДТГ-ын даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар удирдах 6, гүйцэтгэх 13, үйлчлэх 5, нийт 24 орон тоог баталсан ба тайлант онд орон тооны цомхотгол хийгээгүй, тайлант оны эцэст 24 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

2. Сумын Засаг даргын 2025.02.11-ний өдрийн А/21 дүгээр захирамжаар БНХАУ-ын ӨМӨЗО-ны Альшаа аймагт гадаад томилолтын зардалд Засаг даргын нөөц хөрөнгөөс 3,000.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3. Тус байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Санхүүгийн тооцоолох” ХХК-ийн Acolous программ, нярвын программ, хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд “Лүэ” ХХК-ийн “ХХС-ийн программ”-ыг ашиглаж байна. Тайлант онд программын сунгалтад 527.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 49,230.0 мянган төгрөгийн 3 алдаа илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

1. Санхүүгийн тайланд нэмэлт санхүүжилтийн дансны 2,310.0 мянган төгрөгийн орлогыг үндсэн үйл ажиллагааны орлогоор зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Аж ахуйн нэгж,

байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4 дэх “үнэн зөв байх”, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Сумын ИТХ-ын 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн “ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгөд эзэмшигч тогтоох тухай” 51 дүгээр тогтоолоор орлого авахаар шийдвэрлэсэн 30,000.0 мянган төгрөгийн бөхийн дэмжээний хивсийг хөрөнгөд орлого авч бүртгээгүй байна.

3. Аймгийн ИТХ-ын 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн “Автомашин акталж, данснаас хасах тухай” 7/38 дугаар тогтоолоор хөрөнгөд бүртгэлтэй 16,920.0 мянган төгрөгийн Portland авто машиныг “Баян өсөх агро” ОНӨААТҮГ-т сэлбэгээр ашиглуулах шийдвэр гарсан байхад хөрөнгийг данс бүртгэлээс хасаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 дэх “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 22,000.0 мянган төгрөгийн 3 зөрчил¹ илэрснээс, 22,000.0 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоосон.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлийн 22,000.0 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон 12,715.0 мянган төгрөгийн гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшнээс 9,285.0 мянган төгрөгөөр их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

3.1 Төлбөрийн акт

3.1.1. Засаг даргын орлогчоор ажиллаж байсан албан хаагчид 1,000.0 мянган төгрөгийн урьдчилгаа олгосон ба суутган тооцоо хийж авлагаар бүртгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь “Хариуцлагатай байх”, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4 дэх “Үнэн зөв байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Суутган тооцоо хийгээгүй 1,000.0 мянган төгрөгийг төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нараар төлүүлж төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.1.2. Сумын Засаг даргын 2025.11.04-ний өдрийн “Засаг даргын нөөц хөрөнгөөс хөрөнгө зарцуулах тухай” А/140 дүгээр захирамжаар Чех улсад өсвөрийн

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

волейболын тэмцээнд оролцох тамирчинд 1,500.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлэхээр шийдвэрлэсэн байхад 2,500.0 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү шилжүүлсэн 1,000.0 мянган төгрөгийг төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нараар төлүүлж төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.1.3. Сумын ЗДТГ-ын даргын “Сонор иргэдийн оролцоо хамтын хөгжил” НҮТББ-тай 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан “Шинэжинст сумын ОНХС-ийн үйл ажиллагаанд сургалт, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г 20,000.0 мянган төгрөгөөр байгуулж ОНХС-аас санхүүжих ажлыг төсвийн урсгал зардлаас төлж зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалтыг гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зориулалт бусаар зарцуулсан 20,000.0 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн 2026 оны төсвөөс төлүүлж төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

Аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг нотлох баримтын хамт төрийн аудитын байгууллагад төлбөрийн актад заасан хугацаанд ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөг)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланд орлогыг буруу тусган бүртгэсэн	1	2,310.0	-	-	1	2,310.0	1	2,310.0	-	-
Санхүүгийн тайланд хөрөнгийг орлого авч бүртгээгүй	1	30,000.0	1	30,000.0	-	-	1	30,000.0	-	-
Санхүүгийн тайланд хөрөнгийн ангиллыг буруу бүртгэсэн	1	16,920.0	-	-	1	16,920.0	1	16,920.0	-	-
Дүн	3	49,230.0	1	30,000.0	2	19,230.0	3	49,230.0	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Засаг даргын орлогчоор ажиллаж байсан албан хаагчид 1,000.0 мянган төгрөгийн урьдчилгаа олгосон ба суутган тооцоо хийж авлагаар бүртгээгүй байна.	1	1,000.0	1	1,000.0	-	-	-	-	-	-
Сумын Засаг даргын 2025.11.04-ний өдрийн "Засаг даргын нөөц хөрөнгөөс хөрөнгө зарцуулах тухай" А/140 дүгээр захирамжаар Чех улсад өсвөрийн гар бөмбөгийн тэмцээнд оролцох тамирчинд 1.500.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлэхээр шийдвэрлэсэн байхад	1	1,000.0	1	1,000.0	-	-	-	-	-	-

2,500.0 мянган төгрөгийг олгосон байна.										
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Сумын ЗДТГ-ын даргын "Сонор иргэдийн оролцоо хамтын хөгжил" НҮТББ-тай 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан "Шинэжинст сумын ОНХС-ийн үйл ажиллагаанд сургалт, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх гэрээ"-г 20,000.0 мянган төгрөгөөр байгуулж ОНХС-аас санхүүжих ажлыг төсвийн урсгал зардлаас төлж зориулалт бусаар зарцуулсан байна. .	1	20,000.0	1	20,000.0	-	-	-	-	-	-
Дүн	7	105,684.4	3	2,500.0	4	103,184.4	-	-	-	-

-----oOo-----